




Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

► Хөдөлмөрийн ирээдүйн тухай ОУХБ-ын Зууны тунхаг

Олон Улсын Хөдөлмөрийн
Нэг зуун найм дахь удаагийн Бага Хурлаар
2019 оны зургаан сарын 21-нд
Женев хотноо батлав.



ХӨДӨЛМӨРИЙН ИРЭЭДҮЙН ТУХАЙ
ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
ЗУУНЫ ТУНХАГ

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын 100 жилийн ойг тохиолдуулан Женев хотноо хуралдаж буй Олон Улсын Хөдөлмөрийн нэг зуун найм дахь удаагийн бага хурлаараа,

Нийгмийн шударга ёс, даян дэлхийн өнө бат энх тайвныг зөвхөн Засгийн газар, ажилтан, ажил олгогчийн төлөөллийн харилцан уялдаатай, байнгын хамтын ажиллагааны үр дүнд тогтоож болохыг өнгөрсөн зуун жилийн туршлага харуулсан болохыг *анхааралдаа авч,*

Хамтын энэ хүчин чармайлтын үр дүнд хөдөлмөрийн жинхэнэ хүнлэг нөхцөлийг бүрдүүлэхэд түүхэн дэвшил гарч байгааг *хүлээн зөвшөөрч,*

Дэлхийн олон газар нутагт удтал буурахгүй байгаа ядуурал, шударга бус, тэгш бус, эмзэг байдал, мөргөлдөөн үүссэн байгаа нь бидний хүрсэн амжилтыг ухрааж, дэлхийн нийтийн хөгжил цэцэглэлт, аюулгүй байдал, бүх нийтийн зохистой хөдөлмөрийг хангахад аюул учруулж байгааг *хүлээн зөвшөөрч,*

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрэм, Филадельфийн тунхаг (1944)-г заасан зорилго, зорилт, зарчим хэвээр байгааг *сануулан, дахин бататгаж,*

ОУХБ-ын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн тухай Тунхаг (1998), ОУХБ-ын Шударга даяаршлын төлөөх нийгмийн шударга ёсны тухай Тунхаг (2008)-ийн ач холбогдол хэвээр байгааг *тэмдэглэж,*

Нийгмийн шударга ёсны төлөөх үзэл санаа нь нэгэн зуун жилийн өмнө Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагыг анх байгуулах шалтгаан болсон бөгөөд хөдөлмөрийн ирээдүйг чиглүүлж, байгууллагын алсын харааг тогтоох нь Засгийн газар, ажилтан, ажил олгогчоос хамаарна гэдэг итгэл үнэмшилдээ *тулгуурлан,*

Нийгмийн яриа хэлэлцээ нь нийгмийн нэгдмэл байдалд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ бүтээмжтэй, эрүүл эдийн засгийг байгуулах үндсэн нөхцөл болохыг *хүлээн зөвшөөрч,*

Хөдөлмөр бараа, бүтээгдэхүүн биш болохыг *дахин бататгаж,*

Хүчирхийлэл, дарамтаас ангид хөдөлмөрийн ертөнцийг байгуулахын төлөө *хүчин чармайж,*

Хөдөлмөрийн ирээдүйгээ өөрсдийн хүссэнээр цогцлоож, хөдөлмөрийн ертөнцөд тулгарч буй асуудлуудыг даван туулахад олон талт тогтолцоог хөхүүлэн дэмжихийн ач холбогдлыг *онцлон тэмдэглэж,*

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын түншлэгч талууд 1919, 1944 онд тохиролцон хүчин чармайлт гаргаж байсан шигээ нийгмийн шударга ёс, даян дэлхийн өнө бат энх тайвны төлөө нийгмийн хэм хэмжээг сэргээн тогтоож, улам бүр эрчимжүүлж, хүчин чармайлтаа бататгахыг *уриалан*,

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын засаглалыг бүх бүс нутгийн төлөөллийг шударга тогтоож, гишүүн орнуудынхаа дунд тэгш зарчим тогтоох замаар ардчилахыг *эрмэлзэн* хоёр мянга арван есөн оны зургадугаар сарын хорин нэгний өдөр энэхүү Зууны тунхгийг батлав.

I

Бага хурал нь

- A. ОУХБ нь технологийн дэвшил, хүн ам, байгаль, цаг уурын өөрчлөлт, даяаршлын улмаас улам бүр өөрчлөгдөн байгаа хөдөлмөрийн ертөнцийн шилжилтийн энэ үед, шударга бус байдал улам бүр нэмэгдэж, хөдөлмөрийн мөн чанар, ирээдүй, даян дэлхийн энх тайван, хүн бүрийн үнэлэмжид ихээхэн нөлөөлж байгаа энэ цагт зуун жилийн ойгоо тэмдэглэж байна;
- B. Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, өөрөө чөлөөтэй сонгон эрхэлж буй зохистой хөдөлмөрийг хөдөлмөрийн шударга, хүртээмжтэй, баталгаатай ирээдүй гэж харан, түүнд хүрэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, боломжийг алдалгүй ашиглахын тулд шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай байна;
- C. Хөдөлмөрийн энэ ирээдүй нь ядуурлыг бууруулж, хэнийг ч орхигдуулахгүйгээр тогтвортой хөгжих суурь нөхцөл юм;
- D. ОУХБ нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны бодлогын төвд хүний эрх, хүсэл эрмэлзэл, хөдөлмөр эрхэлж буй хүн бүрийн эрх, хэрэгцээг чухалчлан тавих замаар хүн төвтэй хөдөлмөрийн ирээдүйг цогцлоохын төлөө ажиллаж, өөрийн дүрэмд тунхагласан нийгмийн шударга ёсыг тогтоох хүчин чармайлтаа ирж буй хоёр дахь зуун жилдээ зогсолтгүй үргэлжлүүлэх ёстой;
- E. ОУХБ-ын түншлэгч талууд гурван талт засаглалд бүрэн, шударга, ардчилалтай оролцож, дэлхийн өнцөг булан бүрт нийгмийн шударга ёс тогтсоноор тус байгууллагын дэлхийн бүх улс орныг хамарсан бүрэн гишүүнчлэлтэй болох сүүлийн зуун жилийн хүчин чармайлт биелэгдэх боломжтой

гэж тунхаглаж байна.

II

Бага хурал нь

- А. ОУХБ нь дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, хөдөлмөрийн ертөнц эрс өөрчлөгдөж байгааг харгалзан, хөдөлмөрийн ирээдүйн хүн төвтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлээр хүчин чармайлт гаргаж ажиллах ёстой;
- (i) тогтвортой хөгжил, тэр дундаа эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж буй хөдөлмөрийн ирээдүй рүү шударга шилжихийг анхаарах;
 - (ii) технологийн дэвшил, бүтээмжийн өсөлтийг нийгмийн түншлэлээрээ дамжуулан тогтвортой хөгжил, зохистой хөдөлмөрийг дэмжихэд бүрэн ашиглаж, хүн бүрийн нэр хүндийг хамгаалж, тэднийг авьяас чадвар, хүч бололцоогоо ашиглахыг дэмжин, хөгжлийн үр дүнг хүн бүрт шударга хуваарилах;
 - (iii) Засгийн газар, нийгмийн түншлэгч талууд хамтын хариуцлагынхаа хүрээнд
 - одоо, ирээдүйд дутагдаж буй ур чадварын хомсдолыг арилгах,
 - хөдөлмөр эрхлэх байдал улам бүр өөрчлөгдөж байгаа энэ үед боловсрол, сургалтын тогтолцоо нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангаж байгаад онцгой анхаарал хандуулах,
 - ажиллагчдад зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг ашиглах чадвар суулгахын тулд бүх хүмүүсийг насан туршдаа ур чадвар, чадамж, мэргэшилтэй болохыг дэмжих;
 - (iv) бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй хөдөлмөрийг чөлөөтэй сонгох, зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг хангах, тэр дундаа боловсрол, сургалтаас ажлын байранд шилжих шилжилтийг хялбаршуулж, залуучуудыг хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - (v) ахмад ажиллагчдын сонголтыг өргөжүүлж, тэтгэвэрт гартлаа чанартай, бүтээмжтэй, эрүүл орчинд ажиллах боломжийг олгон, нас ахиж байгаа ч идэвхтэй ажиллаж амьдрахад нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 - (vi) тогтвортой, хүртээмжтэй хөгжилд хүрэх нэг чухал хүчин зүйл бол ажиллагчдын эрх бөгөөд тэр дундаа, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээ хийх эрхийг хүлээн зөвшөөрч, үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийг дэмжих;
 - (vii) ажлын байранд жендэрийн тэгш байдлыг хангахад
 - тэгш боломж, тэгш оролцоо, тэгш харилцааг дэмжин, ижил үнэлгээтэй ажилд ижил цалин олгох;
 - гэр бүлийн үүрэг хариуцлагыг хамтран тэнцвэртэй үүрэх;
 - ажлын цагийг зохицуулах зэргээр ажилтан, ажил олгогчийн хооронд ажил амралтын тэнцвэрийг ажлын хэрэгцээ шаардлага, ажилтны шагнал урамшууллыг харгалзан үзэж, тодорхой шийдэлд хүрэх орон зайг бий болгох,

- асаргааны үйлчилгээний салбарт оруулах хөрөнгө оруулалтыг урамшуулах зэрэг асуудлуудаар эрс шинэчлэл хийх хөтөлбөр хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавих;
- (viii) хөдөлмөрийн ертөнцөд хөгжлийн онцлог хөгжилтэй болон эмзэг нөхцөлд байгаа бусад хүмүүст ижил боломж олгож, тэгш байдлыг хангах;
- (ix) Эдийн засгийн өсөлтийн үндсэн хүчин зүйл болсон хувийн хэвшлийг дэмжиж, бизнесийн таатай орчныг бий болгох, тогтвортой бизнесийг, ялангуяа бичил аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, нийгмийн болон эв санааны эдийн засгийг дэмжих замаар зохистой, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, бүх нийтийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх;
- (x) Төрийн албыг томоохон ажил олгогч бөгөөд төрийн үйлчилгээг үзүүлэгчийнх нь хувьд дэмжих,
- (xi) Хөдөлмөрийн удирдлага, хөдөлмөрийн хяналтыг бэхжүүлэх;
- (xii) Дотоодын болон үндэстэн дамжсан үйлдвэрлэл, ажлын зохион байгуулалт, бизнес загварыг төрөлжүүлэх замаар нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэн, зохистой хөдөлмөрийг дэмжиж, бүрэн, бүтээмжтэй ажлыг чөлөөтэй сонгон эрхлэх;
- (xiii) Албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгаж, бүх нийтийн зохистой хөдөлмөрийг дэмжин, ялангуяа олон улсын түвшинд үйл ажиллагаа нь улам бүр нэгдэн ойртож байгаа салбар, бүс нутагт хил дамжсан хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- (xiv) Албан бус эдийн засгаас албан эдийн засагт шилжих шилжилтийг дэмжиж, хөдөө орон нутагт илүү анхаарлаа хандуулан ажиллах;
- (xv) Хангалттай, тогтвортой, хөдөлмөрийн ертөнцийн өөрчлөлтөд нийцсэн нийгмийн хамгааллын тогтолцоог хөгжүүлж, сайжруулах;
- (xvi) Ажиллах хүчний хил дамнасан шилжих хөдөлгөөний асуудлаар авч буй арга хэмжээгээ түншлэгч талуудын хэрэгцээнд нийцүүлэн улам бүр сайжруулан шинэ түвшинд гаргаж, цагаач ажиллагчдын зохистой хөдөлмөрийг хангах асуудлаар тэргүүлж ажиллах;
- (xvii) Олон талт тогтолцоонд идэвхтэй оролцож, бодлогын уялдаа холбоог хангахдаа
 - зохистой хөдөлмөр бол тогтвортой хөгжил, тэр дундаа орлогын ялгаатай байдлыг бууруулж, ядуурлыг устгах үндсэн хөдөлгүүр бөгөөд ялангуяа, мөргөлдөөн, гамшиг, бусад онцгой нөхцөлд байгаа газар нутагт илүү анхаарлаа хандуулан,
 - даяаршлын энэ эрин үед аль нэг улс хөдөлмөрийн хүнлэг нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байх нь бусад улс орны хөгжилд өмнө өмнөхөөсөө улам бүр саад болж байгааг анхааран,

- B. Засгийн газар, ажил олгогч, ажилтны байгууллагын түншлэл, гурван талт хамтын ажиллагаа нь ОУХБ-ын бүхий л үйл ажиллагаа болон гишүүн орнуудын амжилттай бодлого боловсруулах, шийдвэр гаргах үндэс суурь болдог;
- C. Ажлын байрны хамтын ажиллагаа нь аюулгүй, бүтээмжтэй ажлын байрыг бүрдүүлэх арга хэрэгсэл бөгөөд ийм замаар хамтын хэлэлцээ, түүний үр дүнг хүлээн зөвшөөрч, үйлдвэрчний эвлэлийн үүрэг оролцоог улам нэмэгдүүлэх юм.
- D. Хөдөлмөрийн аюулгүй, эрүүл нөхцөл нь зохистой хөдөлмөрийн суурь нөхцөл мөн хэмээн тунхаглаж байна.

III

Бага хурал нь бүх гишүүн орнуудаа үндэсний онцлогоо харгалзан үзэж, дангаар болон хамтаар, гурван талт тогтолцоо, нийгмийн түншлэлийнхээ хүрээнд хөдөлмөрийн ирээдүйг цогцлоох хүн төвтэй хандлагыг хэрэгжүүлэхийн төлөө:

- A. Хөдөлмөрийн ертөнцийн өөрчлөлтийг хүн бүр өөртөө боломж болгон ашиглах чадавхыг бэхжүүлэхдээ
 - (i) бүх боломж, хандлагад жендэрийн тэгш байдлыг үр дүнтэй хангаж;
 - (ii) бүх нийтийн чанартай боловсрол, насан туршийн үр дүнтэй сургалтад хамрагдах;
 - (iii) бүх нийтийн цогц, тогтвортой нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх;
 - (iv) хөдөлмөр эрхлэх насандаа тулгарч буй шилжилтийн үеүдийг даван туулахад идэвхтэй дэмжлэг үзүүлэх замаар хүн бүрийн чадавхыг бэхжүүлж;
- B. Бүх ажиллагчдын эрхийг хангалттай хамгаалахад хөдөлмөрийн асуудлаар ажилладаг байгууллагуудыг бэхжүүлж, ажиллагчдын эрхийг хамгаалах, тодорхой байдлыг хангахад хөдөлмөрийн харилцаа нэг чухал арга хэрэгсэл болж байгааг улам бүр бататгахын зэрэгцээ тодорхой хэмжээнд албан бус эдийн засаг ажиллаж байгааг хүлээн зөвшөөрөхийн ялдамд албан бус эдийн засгаас албан эдийн засаг руу шилжүүлэхэд үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай байна.

Бүх ажиллагсад зохистой хөдөлмөрийн хөтөлбөрт зааснаар хангалттай хамгаалалтад байх эрхтэй бөгөөд үүнд
 - (i) тэдний суурь эрхийг хүндэтгэх;
 - (ii) хангалттай хэмжээний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, эсвэл зөвшилцөх;
 - (iii) ажлын цагийн дээд хязгаарыг тогтоох;
 - (iv) аюулгүй, эрүүл ажлын байраар хангах зэргийг багтааж ойлгоно.
- C. Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой хөдөлмөрийг дэмжихдээ:
 - (i) дээр дурьдсан зорилтуудыг макро-эдийн засгийн бодлогын үндсэн зорилго

- болгож;
- (ii) худалдаа, аж үйлдвэр, салбарын бодлого нь зохистой хөдөлмөр, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн;
 - (iii) хөдөлмөрийн ертөнцийг өөрчлөгдөхөд нөлөөлж байгаа дэд бүтэц болон стратегийн ач холбогдолтой бусад салбаруудад хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж;
 - (iv) тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, тогтвортой бизнес эрхлэлт, инновац, албан бус эдийн засгаас албан эдийн засагт шилжих шилжилтийг дэмжсэн, улмаар энэхүү тунхагт туссан зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бизнес үйл ажиллагааг бодлого, урамшууллаар дамжуулан дэмжиж,
 - (v) Хувь хүний мэдээлэл, түүний нууцлалыг хангасан, хөдөлмөрийн ертөнцөд гарч буй дижитал өөрчлөлт, тухайлбал платформ эдийн засгийн давуу талыг ажиглаж, сул талыг арилгахад чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхийг уриалж байна.

IV

Бага хурал нь:

- A. Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг тогтоох, сурталчлах, соёрхон батлуулах, хэрэгжилтийг хянах нь ОУХБ-д чухал ач холбогдолтой. Энэ нь тус байгууллагыг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний асуудлаар ажилладаг тодорхой, идэвхтэй, цаг үетэйгээ хөл нийлүүлсэн, ил тод байгууллага байхыг шаардаж байна. Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ нь улам бүр өөрчлөгдөж байгаа хөдөлмөрийн ертөнц, тэр дундаа ажиллагчдыг хамгаалах, тогтвортой бизнесийн хэрэгцээ шаардлагыг харгалзаж үзэх бөгөөд хяналтыг үр дүнтэй, бүрэн эрхийнхээ хүрээнд гүйцэтгэх шаардлагатай. ОУХБ нь гишүүн орнууддаа олон улсын хэм хэмжээг соёрхон баталж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- B. Гишүүн орнууд нь ОУХБ-ын суурь конвенцийг соёрхон баталж, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах бөгөөд ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагуудтайгаа зөвлөлдсөний үндсэн дээр ОУХБ-ын бусад конвенцийг соёрхон батлахад анхаарч ажиллана.
- C. ОУХБ нь гурван талт түншийнхээ
 - хүчтэй, төлөөлөх чадамжтай нийгмийн түншлэлийн байгууллага байгуулж, хөгжүүлэхийг дэмжих,
 - дотооддоо болон хил дамнасан хөдөлмөрийн зах зээлд оролцогч байгууллага, хөтөлбөр, бодлого зэрэг холбогдох асуудлуудад идэвхтэй оролцох,
 - хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудлыг бүх түвшиндээ шийдвэрлэж, шаардлагатай тохиолдолд нийгмийн түншлэлийн хүчтэй, нөлөөтэй, хүртээмжтэй тогтолцоог ашиглах чадавхыг бэхжүүлэх үүрэг хүлээж байгаа бөгөөд энэхүү төлөөлөл, яриа хэлэлцээ нь нийгмийг улам бүр нэгтгэн нягтруулж, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн байж, эдийн засгийг бүтээмжтэй, бүрэн ажиллахад чухал үүргийг гүйцэтгэнэ.

- D. ОУХБ-аас гишүүн улс, түншлэгч талууддаа үзүүлэх үйлчилгээ нь өөрийн чиг үүрэгтэй нь бүрэн нийцсэн байх бөгөөд Өмнөд-Өмнөд ба гурван талт хамтын ажиллагаа зэрэг хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүдээр дамжуулан тэдний нөхцөл байдал, хэрэгцээ, тэргүүлэх чиглэл, хөгжлийн түвшинг бүрэн ойлгож, анхаарал тавьсны үндсэн дээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- E. ОУХБ нь нотолгоонд суурилсан чанартай, нөлөөлөхүйц бодлогын зөвлөгөө өгөхийн тулд статистик, судалгаа, мэдлэгийн менежментийн өндөр чадвартай байна.
- F. ОУХБ нь дүрмээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд хөдөлмөрийн ирээдүйн хүн төвтэй хандлагыг бодлогын түвшинд хэрэгжүүлж, уялдааг хангах зорилгоор нийгэм, худалдаа, санхүү, эдийн засаг, байгаль орчны бодлогуудын хүчтэй, хүнд түвэгтэй, чухал холбоо хамаарлыг хангаж, бусад байгууллагуудтай хамтран институтийн бүтцийг бий болгон хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар олон талт тогтолцоонд чухал үүрэг хүлээж байна.

Дээрх дэлгэрэнгүй бичвэрийг ОУХБ-ын Хөдөлмөрийн ирээдүйн тухай Зууны тунхаг болгон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурлын зуун найм дахь удаагийн (Зууны) Бага Хурлаараа Женев хотноо баталж, 2019 оны 6 сарын 21-ний өдөр тунхагласан болно.

Бид энэ бүхнийг үнэн зөв болохыг баталгаажуулан 2019 оны зургадугаар сарын хорин нэгний өдөр гарын үсгээ зурав.

Бага Хурлын Ерөнхийлөгч
ЖОН-ЖАК ЭЛМИГЭР

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий Захирал
ГАЙ РАЙДЕР